



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 25 өдөр


Дугаар 226

Улаанбаатар хот

Геронтологийн үндэсний төвийн
үйл ажиллагааны чиглэл, бүтэц,
орон тоо батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйл, Монгол Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 231 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геронтологийн төвийг Геронтологийн үндэсний төв болгон шинэчлэн тогтоосонтой холбогдуулан төвийн үйл ажиллагааны чиглэл, бүтцийг хавсралтаар баталсугай.
2. Геронтологийн үндэсний төвийн орон тооны дээд хязгаарыг 52 орон тоогоор тогтоосугай.
3. Батлагдсан төсөв, бүтэц зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг тогтоож, мөрдөхийг Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал /Р.Оюунханд/-д зөвшөөрсүгэй.
4. Тус төвийн үйл ажиллагааг удирдлага зохицуултаар ханган ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхбат/-т даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2009 оны 83 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



001441

Эрүүл мэндийн сайдын 2013
оны 11 сарын 26-дэдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

167

Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэл

1. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

Геронтологийн үндэсний төв нь улсын хэмжээнд Насжилт судлал (геронтологи), Наастны эмгэг судлалын (гериатри) мэргэжлээр эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлнэ.

1.1. Геронтологийн үндэсний төвийн эрхэм зорилго

Монгол хүний насхилт түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судалж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлэх замаар үйлчлүүлэгчдийг дээдэлсэн тогтолцоог бүрдүүлэн, хамт олны хөгжил дэвшлийг хангахад оршино.

1.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

1.2.1 Монгол хүний насхилтын байдал түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах үйл ажиллагааг явуулах

1.2.2 Нотолгоонд тулгуурласан геронтологи болон гериатрийн тусlamжийг настан хүн амд үзүүлж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээг хөгжүүлэх

1.2.3 Эрүүл насхилтыг дэмжих олон талт үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, удирдан чиглүүлэх, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх

1.2.4 Геронтологи болон гериатрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн болон бусад байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт үнэлгээ хийн лавлагаа тусlamж үзүүлэх

1.2.5 Геронтологийн үндэсний төвийг өргөжүүлэн хөгжүүлж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх

1.2.6 Насжилт, наастны эмгэг судлалын чиглэлээр эрүүл мэндийн мэргэжилтэн, бусад мэргэжилтэнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, хүн амын зорилтот бүлэг, настанд зориулсан сургалтыг зохион байгуулах

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
06 сарын 1... өдрийн... итогт
тушаалын хоёрдугаар хавсралт

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ /52 орон тоо/

